

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2024 оны 10-р сарын 19-ний өдөр

Цаг: 10:00

Хэлбэр: Танхим

Хэлэлцэх асуудал:

1. Компанийг нэгтгэх
2. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай
3. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай
4. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай
5. Бусад

Тооллогын комиссын дарга М.Уянга хурлын ирц танилцууллаа.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 2,000,000,000 ширхэг энгийн хувьцаанаас тус өдрийн хуралд 1,005,223,719 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 50.26% болж ирц бүрдсэн байна.

Иймд хурлын ирц компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.1-т заасан болон компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн болно.

Хурлын дарга Ч.Тэмүдэр: Тооллогын комисс танилцуулсны дагуу хурлын ирц бүрдсэн тул хурлыг эхлүүлж байна. Хурал эхэлсэнтэй холбогдуулан хурлын дэгийг танилцууллаа.

Эхний хэлэлцэх асуудал болох компани нэгтгэх тухай асуудлыг компанийн Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг танилцуулна уу

Гүйцэтгэх захирал Бадамцэцэг: Сайн байцгаана уу. Компани нь РЭЙН ЖИ ТИ СИ компанитай нэгтгэхээр санал оруулсан байгаа. РЭЙН ЖИ ТИ СИ компани нь 2023 оны 9 дүгээр сард үүсгэн байгуулагдсан компани юм. Одоогоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа. Тус компани толгой компани болох ГҮҮД ТИ СИ компани нь 2021 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд мэдээлэл технологийн үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү компанитай нэгтгэх болсон шалтгаан нь тус компани нь финтек системийг хөгжүүлсэн, ISO зөвшөөрлөө авсан бөгөөд компани онлайн зээлийн үйлчилгээ байхгүй учраас энэхүү компанитай нэгдэх гол шалтгаан болж байгаа юм. Цаашдаа цахим зээлийн үйлчилгээ явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд цалингийн зээл, хэрэглээний зээл гэсэн 2 бүтээгдэхүүнийг гаргахаар төлөвлөж байна. Зээлийн багцдаа тус бүр 1,500,000,000 төгрөг төлөвлөсөн бөгөөд цаашдаа багцаа нэмэгдүүлээд явахаар тооцоолсон байгаа. Нэгдэж байгаа компанийн бизнесийн үнэлээг “Аривжих эстимейт үнэлгээ” ХХК хийлсэн бөгөөд 4,465,306,462 төгрөгөөр үнэлсэн байна. Санал болгох нэгж хувьцааны үнийг Монголын хөрөнгийн биржээс авсан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханш болох 20.93 төгрөгөөр компанийн ТУЗ-ийн хурлаар тогтоосон. Компаниас тус компанид эзэмшүүлэхээр гаргасан хувьцаа нь 213,344,790 ширхэг бөгөөд компанийн нийт гаргасан хувьцаа нь 2,213,344,790 ширхэг хувьцаа болохоор байгаа юм. Компани нэгдсэний дараах хувьцаа эзэмшлийн байдал нь Рэйн Жи Ти Си ХХК нь компанийн 9.64 хувь

эзэмшихээр байна. Нэгдсэний дараах компанийн бүтэц нь иймэрхүү байдалтай байна. Аппликейшн хөгжүүлэлттэй холбоотой мэдээлэл технологийн салбар нэмэгдэх, зээлийн алба нэмэгдэх гээд их өргөн хүрээтэй болж байгаа. Компани нэгтгэхтэй холбоотой хуулийн дагуу 2 журмыг хэрэгжүүлэх эсэхэд та бүхнээс санал авахаар оруулсан. 1. Тэргүүн элжинд худалдан авах эрх , 2. Хувьцааг эргүүлэн худалдаж авах эрх гэсэн хоёр эрх үүсэж байгаа. Энэхүү хоёр эрхийг хэрэгжүүлэх үнийг мөн Монголын хөрөнгийн биржийн сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханш болох 20.93 төгрөгөөр тогтоосон. Дээр дурдсанаар нэмэлт хувьцаа гаргаж байгаагаар холбоотойгоор компанийн дүрэмд өөрчлөл орж байгаа. Компанийн нийт гаргасан хувьцаа одоогоор 2,000,000,000 ширхэг байгаа бол нэмж гаргаснаар 2,213,344,790 ширхэг болж нэмэгдэж байгаа юм.

Хурлын дарга Ч.Тэмүдэр: Баярлалаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал асуулт байна уу.

Асуулт байхгүй бол Тооллогийн комиссын дарга Уянга саналын хуудсаараа саналаа аваад явъя. Тооллогын комиссын дүн гаргал хурал түр завсарлаж байна.

Санал хураалтын дүн гарсан байна. Тооллогын комиссын дарга Уянга танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга М.Уянга:

1. Компанийн нэгтгэх асуудалд хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8 % хувийн саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26 % саналаар татгалзсан байна.
2. Компанийн нэгтгэх асуудалтай холбогдуулан Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх тухай асуудалд хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8 % хувийн саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26 % саналаар татгалзсан байна.
3. Компанийн нэгтгэх асуудалтай холбогдуулан Хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрхийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8 % хувийн саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26 % саналаар татгалзсан байна.
4. Компанийн шинэчилсэн дүрмийн өөрчлөлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8 % хувийн саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26 % саналаар татгалзсан байна.

Хурлын дарга Ч.Тэмүдэр: Хурлын дүнг танилцуулсан тооллогын комиссын даргадаа баярлалаа. Хурлын дүнг танилцуулж дууссан тул өнөөдрийн ээлжит бус хурлыг өндөрлөж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Хурлын дарга:



/Б.Бадамцэцэг/

/ Ч.Тэмүдэр /